



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 1/17

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 2 дахь хэсэг 2.4.3.1, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад заасан нэр бүхий 8 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2018 оны 2 дугаар сарын 13-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжаа бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д тус тус үүрэг болгосугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ХАЛТАЙ

000011

Гүйцэтгэх захирлын 2018 оны 2 дугаар сарын  
18-ны өдрийн 18 тоот тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах  
арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниудын  
нэрс**

1. "Дэлгэрхангай секюритиз ҮЦК" ХХК
2. "Масдак ҮЦК" ХХК
3. "Нэйшнл Секюритис ҮЦК" ХХК
4. "Санар ҮЦК" ХХК
5. "Сикап ҮЦК" ХХК
6. "Тэсо инвестмент ҮЦК" ХХК
7. "Хүннү эмпайр ҮЦК" ХХК
8. "Эм ай си си ҮЦК" ХХК

---oOo---